



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ГАДААД ХУДАЛДААНЫ СТАТИСТИК 2022 I-XII

2023 оны 01 сарын 18 өдөр

ГАРЧИГ

3. ГАДААД ХУДАЛДАА.....	3
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	3
3.1.1. Уул уурхай, олборлох салбар	4
3.1.2. Газрын тосны салбар.....	5
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар.....	5
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт	5
3.2.1. Газрын тосны салбар.....	5

3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 21,244.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 3,836.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,540.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3,299.3 сая ам.доллар буюу 35.7 хувиар өссөн байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 11,754.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 3,133.9 сая ам.доллар буюу 36.4 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.7 хувийг эзэлж байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2021	2022	Өөрчлөлт	
		I-XII		+/-	Хувь
Чулуун нүүрс	\$/тн	175.8	205.0	29.1	16.6%
Зэсийн баяжмал	\$/тн	2,261.1	1,881.8	-379.2	-16.8%
Төмрийн хүдэр, баяжмал	\$/тн	134.0	82.6	-51.4	-38.3%
Цайрын хүдэр, баяжмал	\$/тн	1,566.6	2,006.5	440.0	28.1%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	\$/тн	223.4	285.0	61.5	27.5%
Молибдены баяжмал	\$/тн	11,228.7	13,520.6	2,291.9	20.4%
Алт	\$/кг	58,234.4	57,345.0	-889.4	-1.5%
Катодын зэс	\$/тн	8,990.6	8,246.7	-743.8	-8.3%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: ¹ - дахин их



3.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

Нүүрсний экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 6,502.7 сая ам.долларын 31,814.0 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 3,728.7 сая ам.доллар буюу 2.3 дахин, биет хэмжээгээр 15,696.4 мян.тн буюу 2.0 дахин тус тус өссөн байна. Чулуун нүүрсний 94.0 хувийг БНХАУ, 3.8 хувийг Сингапур Улс, 2.1 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,734.8 сая ам.долларын 1,453.3 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 165.0 сая ам.доллар буюу 5.7 хувиар буурч, биет хэмжээгээр 170.8 мян.тн буюу 13.3 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 391.0 сая ам.долларын 4,732.2 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 561.2 сая ам.доллар буюу 58.9 хувиар, биет хэмжээгээр 2,374.0 мян.тн буюу 33.4 хувиар тус тус буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 110.5 сая ам.долларын 387.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 256.5 мян.тн буюу 39.8 хувиар, үнийн дүнгээр 33.5 сая ам.доллар буюу 23.2 хувиар тус тус буурсан байна. Хайлуур жоншны 46.0 хувийг ОХУ, 53.8 хувийг БНХАУ руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 283.3 сая ам.долларын 141.2 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 28.6 мян.тн буюу 25.4 хувиар, үнийн дүнгээр 106.9 сая ам.доллар буюу 60.6 хувиар тус тус өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 87.2 сая ам.долларын 6,451.1 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 4.8 сая ам.доллар буюу 5.9 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 885.5 тн буюу 12.1 хувиар буурсан байна. Молибдены баяжмалын 89.7 хувийг БНХАУ, 10.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Алтны экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,127.4 сая ам.долларын 19,660.3 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 122.9 сая ам.доллар буюу 12.2 хувиар, биет хэмжээгээр 2,410.7 кг буюу 14.0 хувиар тус тус өссөн байна. Алтны 91.0 хувийг Швейцар, 9.0 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Газрын тосны экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 241.8 сая ам.долларын 2,605.7 мян.бар газрын тос экспортлолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1,743.2 мян.бар буюу 40.1 хувиар, үнийн дүнгээр 31.5 сая ам.доллар буюу 11.5 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортлолсон байна.

3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Коксын экспорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1.0 сая ам.долларын 2.3 мян.тн кокс экспортлолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 7.4 сая ам.доллар буюу 88.0 хувиар, биет хэмжээгээр 29.9 мян.тн буюу 92.8 хувиар тус тус буурсан байна.

Катодын зэс: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 82.6 сая ам.долларын 10,014.1 тн катодын зэс экспортлолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 165.1 тн буюу 1.7 хувиар, үнийн дүнгээр 6.0 сая ам.доллар буюу 6.7 хувиар тус тус буурсан байна. Катодын зэсийг 100 хувь БНХАУ руу экспортлолсон байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 8,704.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,859.0 сая ам.доллар буюу 27.2 хувиар өссөн байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 1,960.3 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 621.7 сая ам.доллар буюу 46.4 хувиар өссөн байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2021	2022	Өөрчлөлт	
		I-XII		+/-	Хувь
Автобензин	тн/ам.дол	682.8	825.0	142.2	20.8%
Дизель түлш	тн/ам.дол	596.7	977.3	380.6	63.8%

Эх сурвалж: ГЕГ

3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 87.9 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна. 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,723.5 сая ам.долларын 1,832.8 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортлолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 68.8 мян.тн буюу 3.9 хувиар, үнийн дүнгээр 591.8 сая ам.доллар буюу 52.3 хувиар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 88.3 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 32.6 хувийг автобензин, 55.7 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.



Автобензиний импорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 561.5 сая ам.долларын 680.5 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 107.8 мян.тн буюу 18.8 хувиар, үнийн дүнгээр 170.4 сая ам.доллар буюу 43.6 хувиар тус тус өссөн байна.

Дизель түлшний импорт: 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 959.7 сая ам.долларын 982.0 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 369.6 сая ам.доллар буюу 62.6 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 6.9 мян.тн буюу 0.7 хувиар буурсан байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ